


Бид хөрөнгийн зах зээлийн оргилд ТУГАА ХАТГАХААР ажиллаж байна



Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийн хувьцааг борлуулж нийт 12.4 тэрбум төгрөг орлогоор авч, үүнээс 3.3 тэрбумыг нь Монгол Шуудан ХК-ийн 17.4 хувийг авахад зориуллаа. Ард Санхүүгийн Нэгдэлийн ТУЗ-ийн дарга Ж.Оюунгэрэл болон Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг Монгол Шуудан ХК-ийн ТУЗ-д сонгогдсон. 1 дүгээр сард Монгол Шуудан ХК-ийн хувьцааны үнэ өсөж, 305-325 төгрөгийн хооронд тогтворжиж, бидний 1 дүгээр улирлын хөрөнгө оруулалтын үнэлгээ 64.9 хувиар өсөж үнэлэгдсэн болно.

2016 оны 1 дүгээр улиралд Хөрөнгө Оруулагч Үндэстэн Фэйсбүүк хөдөлгөөн өрнөж, олон нийтийн оролцоотой Хөрөнгө оруулалтын сан байгуулагдсанаар Монгол Улсын ард иргэдэд банк санхүүгийн салбарт хувьцаа эзэмших үүд хаалгыг нээж өглөө.

1 дүгээр сарын 8-нд Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг Улаанбаатар хотын Гүйцэтгэх захирлуудын (CEO) Клубын Ерөнхийлөгчөөр сонгогдлоо.

Ард Холдингс Монгол Улсын болон Оросын холбооны Буриад Улсын Гавьяат жүжигчин Ганбаатарын Ариунбаатарын тоглолтыг ивээн тэтгэсэн.

Ард Санхүүгийн Нэгдэл нь Корпорэйт Конвэншн Сентэрд (Corporate Convention Center) болсон Монголын Урлагийн Зөвлөлөөс зохион байгуулсан Монголын үндэсний найрал хөгжмийн Морин хуур чуулгын тоглолтыг ивээн тэтгэсэн.

3 дугаар сарын 30-ны ТУЗ-ийн хурлаас Ард Холдингсыг Монголын хөрөнгийн бирж дээр олон нийтэд нээлттэй арилжаалагдах компани болох бэлтгэх ажлыг эхлүүлэхийг Компанийн удирдлагын багт зөвшөөрсөн. ТУЗ-ийн зүгээс хөрөнгө оруулалтын хэд хэдэн хэлэлцээрийг хянан үзэж, зөвшөөрөл өгчээ. Үүнд охин компаниудынхаа бусад жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг авах зэрэг орно. Мөн ТУЗ-ийн зүгээс компанийн 10 хувийг ирэх 4 жилд ажилчид, удирдлагад зориулахаар шийдвэрлэж гүйцэтгэх багт урам зориг өглөө.

4 дүгээр сарын 29-нд болсон Жинст Увс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Жинст Увс ХК Ард Санхүүгийн Нэгдэл ХК-тай нэгдэхээр шийдвэрлэсэн.

Ард Санхүүгийн Нэгдэлийн томоохон хувьцаа эзэмшигч болох ЮБиАйЖи (UBIG) болон Аполло Венчурс (Apollo Ventures) нараас компанийн 20.9 хувьтай тэнцэх хувьцааг буцааж худалдан авсан.

Ард Менежмент ХХК-ийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 2 дугаар сарын 24-нд Санхүүгийн Зохицуулах Хороо олгосноор бид хувийн болон хамтын хөрөнгө оруулалтын сангуудыг байгуулах боломжтой боллоо. Ард Холдингсын ТУЗ ТТДС-ийн 50 хувь, Уайлд Дижитал Эйженсигийн 51 хувь, Номын Хишигийн 20 хувь болон Тэнгэр Системсийн 90 хувийг ЕИТ гэх хаалттай сан руу шилжүүлж, цаашид Ард Менежментийн удирдлага руу шилжүүлэхийг зөвшөөрөв. Мөн Ард Менежментийн удирдлага доор Хөрөнгө Оруулагч Үндэстэн санг үүсгэн байгуулахыг зөвшөөрсөн байна.

2016 оны 1 дүгээр улиралд Хөрөнгө оруулагчидтай харилцах менежер, ТУЗ-ийн нарийн бичиг нарыг шинээр томилсон. ТУЗ-ийн гишүүд 3 дугаар сарын хурлаар Эрсдэл хариуцсан захирал, Хуулийн захирал, Дотоод аудитор зэрэг ажилтнуудыг нэмж авахыг үүрэг болгосон.

1 дүгээр сард Гүйцэтгэх захирал Ч. Ганхуяг АНУ-ын Атланта хотод болсон "Hope Financial Inclusion" олон улсын санхүүгийн зах зээлийн чуулга уулзалтад оролцлоо.

Ард Санхүүгийн Нэгдэлийн компаниуд гэрээ хэлэлцээрүүдээ Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх Арбитраар шийдвэрлүүлдэг болсон.

Ард Холдингс ба Хөрөнгө Оруулагч Үндэстэн хөдөлгөөнийхөн Монгол орныхоо өнцөг булан бүрт хүрэх, хөрөнгө оруулагчдынхаа эгнээг тэлэх, үйл ажиллагаагаа олон нийтэд таниулан сурталчлах зорилготойгоор 4 дүгээр сарын 15-аас 20-ны хооронд Дархан, Эрдэнэт хотод ажилласан.

4 дүгээр сарын 21-ний өдөр Ард Санхүүгийн Нэгдэл Хаалттай Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал амжилттай болж өнгөрлөө.

Санхүүгийн тайлан - 1 дүгээр улирал 2016

/мянган төгрөгөөр/

Баланс	2015-I улирал	2015-IV улирал	2016-I улирал
Мөнгөн хөрөнгө	59,404	1,328,120	169,124
Авлага, БМ	159,930	7,481,561	355,090
Бусдад олгосон зээл	968,369	3,325,736	9,179,583
Урьдчилж төлсөн тооцоо	169,816	127,526	244,048
Үндсэн хөрөнгө	1,327,133	1,537,606	1,416,955
Хөрөнгө оруулалт	31,893,599	20,844,828	24,280,264
НИЙТ ХӨРӨНГӨ	34,578,252	34,645,378	35,645,063
Дансны өглөг	635,545	5,317,265	74,737
Бусдаас авсан зээл	84,999	668,228	862,702
Татварын өр	14,090	51,471	148,471
УОО	4,043,199	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	154,510	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,932,342	6,036,965	1,085,910
Энгийн хувьцаа	1,643,865	1,359,731	1,719,436
Нэмж төлөгдсөн капитал	8,795,768	4,893,178	9,789,740
Дахин үнэлгээний нэмэгдэл	7,615,095	7,615,095	7,615,095
Эздийн өмчийн бусад хэсэг	13,799	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	11,492,906	11,492,906	14,726,610
Тайлант үеийн цэвэр ашиг	84,478	3,233,705	694,472
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	29,645,910	28,608,413	34,559,152
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	34,578,252	34,645,378	35,645,063

Орлого үр дүнгийн тайлан	2015-I улирал	2015-IV улирал	2016-I улирал
Хөрөнгө оруулалтын орлого	3,538	-	-
Хүүний орлого	38,810	210,810	125,482
Ноогдол ашгийн орлого	50,000	206,529	-
Түрээсийн орлого	41,494	130,725	36,000
Менежментийн орлого	52,003	109,171	30,000
Ханшийн зөрүүгийн ашиг (цэвэр)	44,716	89,090	959,194
НИЙТ ОРЛОГО	230,561	751,356	1,150,677
Боловсон хүчний зардал	37,281	245,996	104,513
Үйл ажиллагааны зардал	90,639	890,138	268,543
Санхүүгийн зардал	9,281	87,177	5,984
НИЙТ ЗАРДАЛ	137,202	1,223,312	379,041
Татвар төлөхийн өмнөх ашиг	93,359	(471,956)	771,636
ХО-ын ашиг		4,041,899	
Татвар төлөхийн өмнөх ашиг	93,359	3,569,943	771,636
Орлогын татварын зардал	8,881	336,238	77,164
Тайлант үеийн цэвэр ашиг	84,478	3,233,705	694,472

Хувьцаа эзэмшигчид

№	Хувьцаа эзэмшигчид	2014-IV улирал Хувьцаа	%	2015-IV улирал Хувьцаа	%	2016-I улирал Хувьцаа	%
1	Интергрупп ХХК	2,237,050	13.32	1 871,276	13.9	1 771,276	13.5
2	Луна Луна ХХК	1,284,893	7.65	1 373,801	10.2	1 450,801	11.0
3	Ventures One BV	1,304,043	7.76	1 304,043	9.7	1 304,043	9.9
4	Чулуун Ганхуяг	1,290,000	7.68	1 290,000	9.6	1 290,000	9.8
5	МАК ХХК	873,000	5.20	873,000	6.5	873,000	6.6
6	Галням Уянга	423,034	2.52	431,589	3.2	536,739	4.1
7	Баяртогтох Нэмэхбаатар	507,834	3.02	507,834	3.8	507,834	3.9
8	Бруно Рашле			461,016	3.4	461,016	3.5
9	Хулдорж Бүрэн-Эрдэнэ	306,000	1.82	457,300	3.4	457,300	3.5
10	Сэдбазар Гэрэлтуяа	450,000	2.68	452,000	3.4	452,000	3.4
11	Лхагвасүрэн Соронзонболд	453,210	2.70	405,210	3.0	405,210	3.1
12	Ронко Лимитэд	220,447	1.31	305,697	2.3	305,697	2.3
13	Мөнх-Очир Сэргэлэн	340,794	2.03	350,794	2.6	257,794	2.0
14	Мягмарсүрэн Золжаргал	300,000	1.79	300,000	2.2	251,000	1.9
15	Чулуун Ганзориг			229,940	1.7	229,940	1.7
16	UBIG ХХК	1,907,059	11.35	-	0.0	-	0.0
17	Аполло Венчурс ХХК	1,690,000	10.06	-	0.0	-	0.0
18	Дүгэрсүрэн Бат-Очир	313,650	1.87	313,650	2.3	-	0.0
	Том 15	13,680,567	81.45	10,927,150	81	10,553,650	80.3
	Бусад	3,114,766	18.55	2,559,209	19	2,594,512	19.7
	Саналын эрхтэй хувьцаа	16,795,333	100.00	13,486,359	100	13,148,162	
	Саналын эрхгүй хувьцаа			3,708,005		4,126,024	
	Гаргасан хувьцаа	16,795,333		17,194,364		17,274,186	
	Халаасны хувьцаа	1,540,179		1,602,164		1,522,342	
	Нийт хувьцаа	18,335,512		18,796,528		18,796,528	

Үнэлгээ

	2014-IV улирал	2015-IV улирал	2016-I улирал	%
Урт хугацаат ХО	32,331.08	20,844.83	26,124.37	
Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК	11,684.77	-	-	4.3
Монгол Шуудан ХК			5,279.54	17.4
ТТДС ХХК	9,824.90	9,824.90	9,824.90	50.0
Ард Даатгал ХХК	6,637.20	6,337.20	6,337.20	55.3
Ард Кредит ХХК	1,600.00	1,852.90	1,852.90	58.0
Ард Секюритиз ХХК	983.00	983.00	983.00	100.0
Номын Хишиг ХХК	1,382.40	1,382.40	1,382.40	20.0
Бусад	218.81	464.43	464.43	
Богино хугацаат ХО	958.61	3,325.88	3,404.97	
Нийт	33,289.70	24,170.71	29,529.34	
Бусад	709.84	5,180.74	1,099.27	
Үндсэн хөрөнгө	897.32	1,623.34	1,416.95	
Мөнгө хөрөнгө	408.47	1,328.48	169.12	
Цэвэр авлага	(595.95)	2,228.92	(486.81)	
Нийт үнэлгээ	33,999.54	29,351.45	30,628.61	
Нийт саналын эрхтэй хувьцаа	16,795,333	13,486,359	13,148,162	
Нэгж хувьцааны үнэлгээ	2,024	2,176.38	2,329.50	



Ард Холдингс ба Хөрөнгө Оруулагч Үндэстэн Эрдэнэт хотод



Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал



Блүүмберг ТВ Монголиа-гаар хийлгүүлсэн Ард Холдингсын видео танилцуулганы хэсэг



Ердийн даатгал



Банк бус санхүүгийн байгууллага



Хадгаламж зээлийн хоршоо



Брокер, диллер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх



Хөрөнгө оруулалтын менежмент



Шуудангийн Цогц Шийдэл



Санхүүгийн програм хангамж



Техникийн дээд боловсрол, Коосан сургууль



Хөрөнгө оруулалтын сан



Хөрөнгө оруулалтын сан



Үл хөдлөх хөрөнгийн түрээс



Вэб сайт, маркетинг, брендинг хөгжүүлэлт



Хөрөнгө оруулалтын сан



WWW.ARDHOLDINGS.COM



INFO@ARDHOLDINGS.COM



7707-8080

"АРД ХОЛДИНГС"-ЫН БАЙР 2 ДУГААР ДАВХАР
ЕРӨНХИЙ САЙД АМАРЫН ГУДАМЖ, СУХБААТАР ДҮҮРЭГ